



МОНГОЛ УЛСЫН НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

19 96 оны 7 дугаар
сарын 6, өдөр

Дугаар 21.33

Улаанбаатар
 хот

Улаанбаатар хотын "Хүрээ зам"
концерний тухай

1. Нийслэл болон түүний дагуул хотын авто замыг барих, засаж арчлах ажлыг шинжлэх ухааны үндсэн дээр төлөвлөх, судалгаа шинжилгээ хийх, авто зам, гүүр, гудамжны нухэн гарц, талбай барих, засварлах, замын хайгуул, зураг төсөл гүйцэтгэх, хотын замын норм, стандарт боловсруулах, зам барилгын материал үйлдвэрлэх үүрэг бүхий төрийн өмч давамгайлсан Улаанбаатар хотын "Хүрээ зам" концернийг байгуулж ажиллуулах тухай үүсгэн байгуулагчдын саналыг сайшаан дэмжсүгэй.

2. Төрийн өмч давамгайлсан Улаанбаатар хотын "Хүрээ зам" концерний бүрэлдэхүүнд хотын харьяа төрийн өмчийн оролцоотой "Чандмань ХК" компани, Хот тохижилтын компани /УУГ/-иудыг оруулж ажиллуулахыг зөвшөөрсүгэй.

3. Улаанбаатар хотын авто замыг хөгжүүлэх боллогыг төрийн өмчийн төлөөлөөр дамжуулан хэрэгжүүлж байхыг хотын ерөнхий менежер /н.Бямбаа/-д даалгасугай.


4. Улаанбаатар хотын "Хүрээ зам" концерний бүрэлдэхүүнд ажиллах аж ахуйн нэгжүүдийн хооронд байгуулах гэрээ, дүрмийг аж ахуйн нэгжийн хуулийн дагуу боловсруулан мөрдөж ажиллахыг "Хүрээ зам" концернид зөвлөсүгэй.

5. Улаанбаатар хотын "Хүрээ зам" концернийг түүний тэргүүлэх чиглэлийн үйлдвэр болох ШУҮ-ийн "Авто зам" нэгдлийн одоогийн байранд зохих газруудтай тохиролцсоны дагуу төвлөрүүлэн байрлуулахыг зөвшөөрсүгэй.

6. Ойрын жилүүдэд нийслэл хот, түүний дүүрэг, дагуул хотын авто зам, гүүр, нухэн гарц, гудамж талбайг барих, засаж сайж-

2.

руулах, эрдэм шинжилгээ, судалгаа, зураг төсөл, хайгуул хийх ажлын жагсаалт, хөрөнгө оруулалт, санхүүжилтийн төслийг "Хүрээ зам" концернтай хамтран 1995 оны 8 дугаар сард боловсруулж нийслэлийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг хотын ерөнхий менежер /н.Бямбаа/-д даалгасугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ЦАРГА
БАГӨӨД УЛААНБААТАР
ХСТЫН ЗАХИРАГЧ

Ц.БААСАНЖАВ

Ц.БААСАНЖАВ